

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ-106
ДЕЛЬТАПЛАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	2
106.1 Зорилго.....	2
106.3 Тодорхойлолт.....	2
106.5 Нисгээгчид тавигдах шаардлага.....	2
106.7 Дельтапланы Нислэгт тэнцэх чадвар	2
106.9 Бүртгэл.....	3
106.11 Дельтапланы бичиг баримт	3
106.13 Шатахууны шаардлага	3
106.15 Дельтапланы тоноглол	3
106.17 Дельтапланы засвар үйлчилгээ	3
106.19 Аюулгүйн тоног төхөөрөмж	3
Б БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ЖУРАМ	4
106.51 Нислэгийн хөдөлгөөнд оролцох журам	4
106.53 Үүлэн доогуурх нислэг	4
106.55 Хамгийн доод өндөр	4
106.57 Нислэгийн нөхцөл	4
106.59 Хөөрөлт үйлдэх газар.....	4
106.61 Нислэгийн өндөр	4
106.63 Уран жолоодлого	4
106.65 Дуудлагын дохио.....	4

*Зам, тээвэр, барилга хот байгуулалтын
сайдын 2010 оны 05 дугаар сарын 07 -ны
өдрийн 160 дугаар тушаалын 13 дугаар хавсралт*

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ-106

ДЕЛЬТАПЛАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

106.1. Зорилго

(а) Энэ дүрмийн зорилго нь:

- 1/ дельтапланы үйл ажиллагаанд хамаарах ИНД-91-ийн нэмэлт журмыг тогтоох, ба
- 2/ ИНД-91-ийн зарим заалтаас дельтапланы үйл ажиллагааг чөлөөлөхөд тус тус оршино.

106.3. Тодорхойлолт

Гэрчилгээ гэж аливаа этгээдэд эрх бүхий байгууллагаас, энэ дүрмийн шаардлагын дагуу, нислэг үйлдэхийг зөвшөөрч олгосон баримтыг,

Дельтаплан гэж аливаа хүчний төхөөрөмжийн тусламжгүйгээр агаартай харилцан үйлчилснээр агаарын урсгалын нөлөөллөөр агаарт дүүжлэгдэн, хөдөлгөөн үйлдэх агаараас хүнд нисэх төхөөрөмжийг;

Эрх бүхий байгууллага гэж ИНЕГ-ын даргаас, энэ дүрмийн дагуу дельтапланы үйл ажиллагаа явуулах, түүнд хяналт тавих эрх олгогдсон байгууллагыг тус тус хэлнэ.

106.5. Нисгэгчид тавигдах шаардлага

(а) Дельтапланы нисгэгч нь:

- 1/ 18 нас хүрсэн;
- 2/ эрх бүхий байгууллагаас олгосон дельтапланы нисгэгчийн хүчин төгөлдөр гэрчилгээ эзэмшигч байх, ба
- 3/ дельтапланы хувьд тогтоож өгсөн стандарт, журмыг баримталж ажиллана.

106.7. Дельтапланы Нислэгт тэнцэх чадвар

(а) ИНД-91-ийн холбогдох шаардлага нь дельтапланд хамаарахгүй боловч аюулгүй нисэх нөхцөлийг хангасан байна.

106.9. Бүртгэл

(а) ИНД-91-ийн холбогдох шаардлага нь дельтапланы үйл ажиллагаанд хамаарахгүй.

(б) Дараах шаардлага хангагдаагүй тохиолдолд дельтапланы нисгэгч нь нислэгийг үйлдэхгүй:

- 1/ дельтаплан нь зөвшөөрөгдсөн журмын дагуу эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй бол;
- 2/ доорх таних тэмдэг олгогдоогүй бол:
 - 2.1 дельтапланы таних тэмдэг;
 - 2.2 нисгэгчийн ялгах дугаар.

106.11. Дельтапланы бичиг баримт

(а) ИНД-91-ийн холбогдох шаардлага нь дельтапланы нисгэгчид хамаарахгүй.

106.13. Шатахууны шаардлага

(а) ИНД-91-ийн холбогдох шаардлага нь дельтапланы нисгэгчид хамаарахгүй.

106.15. Дельтапланы тоноглол

(а) ИНД-91-ийн Е бүлэгт заасан шаардлага нь дельтапланы нисгэгчид хамаарахгүй.

(б) Дельтаплан нь, газрын гадаргуугаас дээшхи өндрийг даралтаар, 30 м (100 фут) –ээс ихгүй зөрүүтэй, заах өндрийн хэрэглэлээр тоноглогдсон байна.

106.17. Дельтапланы засвар үйлчилгээ

(а) ИНД-91-ийн Ж бүлэгт заасан шаардлага нь дельтапланы нисгэгчид хамаарахгүй.

(б) Дельтапланыг "нислэг үйлдэхэд бэлэн" гэсэн баталгааг ИНЕГ-аас гэрчилгээжсэн байгууллагаас гаргасан гэдгийг дельтапланы нисгэгч бататгана.

106.19. Аюулгүйн тоног төхөөрөмж

(а) Дельтапланы нисгэгч нь:

- 1/ ИНЕГ-аас гэрчилгээжсэн байгууллагын стандартад тохирсон хатуу хамгаалалт бүхий дуулга малгайтай байх, ба
- 2/ ИНЕГ-аас гэрчилгээжсэн байгууллагын стандартад тохирсон хамгаалалтын бэхэлгээ бүстэй байна.

Б БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ЖУРАМ

106.51. Нислэгийн хөдөлгөөнд оролцох журам

(а) ИНД-91-д заасныг үл харгалзан, уулын эрэгцэг дээгүүр хөөрч байгаа дельтапланы баруун гар талд уулын эрэгцэг байгаа тохиолдолд эгц урдаас ойртох өөр дельтапланд зам тавьж баруун гар тал руу эргэхийг энэ дүрмээр шаардахгүй.

(б) ИНД-91-д заасныг үл харгалзан, дельтаплан нь уулын эрэгцэг дээгүүр хөөрч байхдаа өөр дельтапланыг гүйцэж түрүүлэх тохиолдолд уулын эрэгцэг талаар тойрч түрүүлнэ.

106.53. Үүлэн доогуурх нислэг

(а) ИНД-91-д заасныг үл харгалзан, G ангиллын агаарын зайд нислэг үйлдэж байгаа дельтаплан нь үүлнээс 150 м (500 фут)-ийн доогуур, далайн түвшнээс дээш 3600 м (11000 фут) хүртэлх өндөрт нислэг үйлдэнэ.

106.55. Хамгийн доод өндөр

(а) ИНД-91-д заасныг үл харгалзан, дельтаплан нь газар дээрх хүн ба өмч хөрөнгөд хохирол учруулахгүйгээр 150 м (500 фут)-ээс бага өндөрт нислэг үйлдэж болно.

106.57 . Нислэгийн нөхцөл

(а) Дельтапланаар шөнийн цагт нислэг үйлдэхийг хориглоно.

106.59. Хөөрөлт үйлдэх газар

(а) Дельтапланы нисгэгч нь эрх бүхий байгууллагаас хөөрөлт үйлдэхийг зөвшөөрсөн газраас хөөрөлт үйлдэнэ.

106.61. Нислэгийн өндөр

(а) ИНД-91-ийн холбогдох шаардлагууд нь дельтапланы нислэгт хамаарахгүй.

106.63. Уран жолоодлого

(а) ИНД-91-ийн холбогдох шаардлагууд нь дельтапланы нислэгт хамаарахгүй.

106.65. Дуудлагын дохио

(а) Дельтапланы нисгэгч нь хоёр талын радио холбоогоор НХҮА-тай харьцахдаа нисгэгчийн ялгах дугаараа хэлнэ.

* * *